

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 28-ны
өдөр

Улаанбаатар хот

2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцно.

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн алба /цаашид “төрийн алба” гэх/-ны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавих шаардлага, төрийн алба хаах болзол, журам, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, баталгаа, төрийн албаны төв байгууллагын чиг үүргийг тогтоон зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хууль тогтоомж

2.1.Төрийн албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Төрийн алба, түүний ангилал

3.1.Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ.

3.2.Төрийн албаны мөн чанар нь ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.

3.3.Төрийн албыг дор дурдсанаар ангилна:

3.3.1.төрийн улс төрийн алба;

3.3.2.төрийн захиргааны алба;

3.3.3.төрийн тусгай алба;

3.3.4.төрийн үйлчилгээний алба.

3.4.Энэ зүйлийн 3.3.2, 3.3.3-т заасан албыг төрийн жинхэнэ алба гэнэ.

4 дүгээр зүйл.Төрийн албаны зарчим

4.1.Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасанчлан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн албаны үндсэн зарчим мөн.

4.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албанд дараахь зарчмыг баримтална:

4.2.1.захирах, захирагдах ёс;

4.2.2.ил тод байх;

4.2.3.ард түмэнд үйлчлэх;

4.2.4.иргэд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албанд орох адил тэгш боломжтой байх;

4.2.5.төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх;

4.2.6.төрийн албан хаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, баталгааг төр хангах;

4.2.7.хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН АЛБАН ТУШААЛ

5 дугаар зүйл.Төрийн албан тушаалын ангилал, төрөл

5.1.Төрийн албан тушаалыг дор дурдсанаар ангилна:

5.1.1.төрийн улс төрийн;

5.1.2.төрийн захиргааны;

5.1.3.төрийн тусгай;

5.1.4.төрийн үйлчилгээний.

5.2.Энэ зүйлийн 5.1.2, 5.1.3-т заасан албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал гэнэ.

5.3.Төрийн албан тушаал нь удирдах, гүйцэтгэх, туслах гэсэн төрөлтэй байна.

5.4.Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

5.5.Энэ хуулийн 5.4-т заасан төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаатай адилтгах албан тушаалтны зэрэглэлд хамаарах төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

6 дугаар зүйл.Төрийн улс төрийн албан тушаал

6.1.Төрийн улс төрийн албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийнх нь хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны дараахь албан тушаал хамаарна:

6.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч;

6.1.2.Монгол Улсын Их Хурлын дарга;

6.1.3.Монгол Улсын Ерөнхий сайд;

6.1.4.Монгол Улсын Их Хурлын дэд дарга, гишүүн;

6.1.5.Монгол Улсын Засгийн газрын гишүүн;

6.1.6.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;

~~6.1.7.дэд сайд;~~

/Энэ заалтыг 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

6.1.8.дэд сайд, Ерөнхий сайдын зөвлөх;

/Энэ заалтыг 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

6.1.9.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;

6.1.10.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх;

~~6.1.11./Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

6.1.12.бүх шатны Засаг дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хууль, 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан/

6.1.13./Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

6.1.14.улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал;

6.1.15.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал;

6.1.16.хуульд заасан бусад албан тушаал.

6.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, хот, тосгоны захирагчийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай адилтган үзэж болно.

6.3.Энэ зүйлийн 6.1.14-т заасан албан тушаал эрхэлдэг ажилтан нь улс төрийн тухайн албан тушаалтанд захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд холбогдох төрийн байгууллагын ажлын албанд харьяалагдана.

6.4.Улс төрийн албан тушаалтан хуульд заасан үндэслэлээр уг албан тушаалаас өөрчлөгдвөл энэ зүйлийн 6.1.14-т заасан ажилтан чөлөөлөгдөнө. Гэхдээ шинээр сонгогдсон буюу томилогдсон төрийн улс төрийн албан тушаалтан хүсвэл уг ажилтныг өөрт нь үйлчлэх орон тооны ажилтнаар үргэлжлүүлэн ажиллуулж болно.

7 дугаар зүйл.Төрийн захиргааны албан тушаал, түүний ангилал

7.1.Төрийн захиргааны албан тушаалд төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах чиг үүрэг бүхий дараахь албан тушаал хамаарна:

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

7.1.1.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүх, Үндсэн хуулийн цэц, прокурорын байгууллагын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.2.Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны албан тушаал;

7.1.3.Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны, бүх шатны шүүхийн тамгын газар, судалгааны төв, бусад туслах нэгжийн болон энэ хуулийн 8.1.2-т зааснаас бусад Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хорооны ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ заалтад 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7.1.4.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.5./Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

7.1.6.Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.7.Монгол Улсын яамны Төрийн нарийн бичгийн дарга, яам болон хуульд өөрөөр заагаагүй бол тохируулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлагийн удирдах болон гүйцэтгэх албан тушаал;

/Энэ заалтыг 2003 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ заалтад 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хууль, 2009 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/

7.1.8.Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн;

7.1.9.Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

7.1.10.хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх улсын төсвөөс санхүүждэг нутгийн захиргааны байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

/Энэ заалтыг 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар нэмсэн, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ заалтад 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7.1.11.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

/Энэ заалтын дугаарт 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7.1.12./Энэ заалтыг 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

7.1.13.хуульд заасан бусад албан тушаал.

/Энэ заалтын дугаарт 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хууль, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт оруулсан/

7.2.Төрийн захиргааны албан тушаалыг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын гэж бүлэглэнэ.

7.3.Төрийн жинхэнэ албан тушаалыг дор дурдсанаар ангилна:

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7.3.1.тэргүүн түшмэл;

7.3.2.эрхэлсэн түшмэл;

7.3.3.ахлах түшмэл;

7.3.4.дэс түшмэл;

7.3.5.туслах түшмэл.

7.4.Тэргүүн түшмэлийн албан тушаалд яамны Төрийн нарийн бичгийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

7.5.Эрхэлсэн түшмэлийн албан тушаалд яамны газрын дарга, хэлтсийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7.6.Ахлах түшмэлийн албан тушаалд яамны тасгийн дарга, ахлах шинжээч, шинжээч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

/Энэ хэсэгт 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

7.7.Дэс түшмэлийн албан тушаалд яамны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

/Энэ хэсэгт 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

7.8.Туслах түшмэлийн албан тушаалд яамны зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

/Энэ хэсэгт 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

7.9.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

/Энэ хэсгийг 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хууль, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан/

7.10. Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

8 дугаар зүйл. Төрийн тусгай албан тушаал

8.1. Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах, нийгмийн хэв журмыг хамгаалахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараахь албан тушаал хамаарна:

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

8.1.1. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;

8.1.2. Монголбанкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн газрын дарга, дэд дарга;

/Энэ заалтад 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

8.1.3. Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

8.1.4. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, цагдаагийн төв байгууллагын дарга, улсын хил хамгаалах байгууллагын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, шүүхийн шинжилгээний байгууллагын дарга;

/Энэ заалтад 2005 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт, 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт, 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмэлт, 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

8.1.5. дипломат албан тушаал;

/Энэ заалтад 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

8.1.6. зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын

офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн;

/Энэ заалтад 2003 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн хууль, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт, 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмэлт, 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

8.1.7.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

8.1.8.хуульд заасан бусад албан тушаал.

/Энэ заалтын дугаарт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

8.2.Төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэвийг хууль тогтоомжид заасны дагуу тогтооно.

9 дүгээр зүйл.Төрийн үйлчилгээний албан тушаал

9.1.Төрийн үйлчилгээний албан тушаалд төрийн суурь үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараахь албан тушаал хамаарна:

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

9.1.1.төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал;

9.1.2.боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг зэрэг улсын төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах ба гүйцэтгэх, туслах албан тушаал;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хууль, 2009 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан/

9.1.3./Энэ заалтыг 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

9.1.4.яам, агентлагийн харьяа буюу дэргэд ажилладаг, улсын төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах ба гүйцэтгэх албан тушаал.

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

9.1.5./Энэ заалтыг 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн, 2003 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

9.2.Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

10 дугаар зүйл.Төрийн албан тушаалд тавих шаардлага

10.1.Төрийн албан тушаалд тавих ерөнхий шаардлага нь хуульд өөрөөр заагаагүй бол тухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай, мэргэшсэн байх явдал мөн.

10.2.Энэ хуулийн 5.1.1, 5.1.3-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

10.3./Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

10.4.Энэ хуулийн 5.1.2-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

10.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг болон улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахихтай холбогдсон зохицуулалтыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн гэрээ, контрактаар тодорхойлно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

10.6.Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч нь төрийн албан тушаал эрхлэх хугацаандаа улс төрийн аливаа нам, хөдөлгөөний үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцохгүй байх, хэрэв улс төрийн намын гишүүн бол намын гишүүнээс түдгэлзэж, тухайн төрийн албан тушаалд томилогдсон өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ тухайгаа байгууллагын захиргаа болон харьяалах намдаа бичгээр албан ёсоор мэдэгдэнэ.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

10.7.Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалд сонгогдсон, эсхүл томилогдсон этгээд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 101.4 дэх хэсэгт заасан арга хэмжээг авна.

/Энэ хэсгийг 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуулиар нэмсэн/

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ

11 дүгээр зүйл.Төрийн албан хаагч

11.1.Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ.

11.2.Энэ хуулийн 5.1.2, 5.1.3-т заасан албан тушаалын ангиллын хүрээнд төрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалыг мэргэшлийн үндсэн дээр байнга эрхэлж байгаа Монгол Улсын иргэнийг төрийн жинхэнэ албан хаагч гэнэ.

11.3.Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

11.4.Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдлыг энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

11.5.Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Хөдөлмөрийн хууль, энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

11.6.Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна.

12 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг

/Энэ зүйлийн гарчигт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

12.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн төрийн жинхэнэ албанд анх орохдоо: “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ” хэмээн тангараг өргөнө.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

12.2.Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтооно.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

13 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг

13.1.Төрийн жинхэнэ албан хаагч нь дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

13.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

13.1.2.өргөсөн тангарагтаа үнэнч байх;

13.1.3.эх орон, ард түмнийхээ тусын тулд иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллах;

13.1.4.харьяа дээд шатны албан тушаалтны хуульд нийцсэн шийдвэрийг биелүүлэх;

13.1.5.төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх;

13.1.6.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн мэргэшлээ дээшлүүлэх;

13.1.7.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон тухайн албан тушаалыг эрхлэхээ зогсоосноос хойшхи хугацаанд төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах;

13.1.8.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахих, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр төр, засгийн бодлоготой холбогдсон асуудлаар зөвхөн албан ёсны байр суурийг илэрхийлэх;

13.1.9.албан тушаалтны хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байх;

13.1.10.төрийн албан тушаалд томилогдмогц өөрийн өмчийн байдлын талаар мэдэгдэж, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар зохих байгууллагад мэдээ өгч байх;

13.1.11.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

14 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг эрх

14.1.Төрийн жинхэнэ албан хаагч дараахь нийтлэг эрх эдэлнэ:

14.1.1.төрийн тухайн албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтыг албан ёсоор гаргуулан авах, түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийг шаардах;

14.1.2.үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлт, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн талаар харьяалах дээд шатны удирдах ажилтны үнэлгээг зөвшөөрөх, эс зөвшөөрөх;

14.1.3.цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэл дэвших, ажиллах нөхцөл, баталгаагаа сайжруулахтай холбогдсон саналыг дээд шатныхаа албан тушаалтанд амаар буюу бичгээр тавих;

14.1.4.өөрийн хувийн хэрэг болон түүнд оруулах ажил байдлын тодорхойлолт зэрэг материалтай танилцах, шаардлагатай гэж үзвэл хувийн хэрэгтээ нэмэлт тайлбар хийх;

14.1.5.өөрийн хууль ёсны ашиг сонирхлыг шүүх болон холбогдох бусад байгууллагаар хамгаалуулах;

~~14.1.6./Энэ заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~14.1.7./Энэ заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

14.1.8.төрийн албанаас чөлөөлөгдөх;

14.1.9.хууль тогтоомжид заасан бусад эрх.

15 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

15.1.Төрийн жинхэнэ албан хаагч дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

15.1.1.албан үүрэгтэйгээ холбогдолгүй асуудлаар нам, төрийн бус болон шашны байгууллагын үйл ажиллагаанд төрийн албан хаагчийн хувьд оролцох;

/Энэ заалтад 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

15.1.2.ажил хаялт болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

15.1.3.албан тушаалын бүрэн эрхээ шашны, эсхүл шашингүйн үзлийн ухуулга, сурталчилгаа хийхэд ашиглах;

15.1.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр гадаад орны төрийн дээд цол, одон, медаль, төрийн бусад шагнал авах;

15.1.5.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан болон Монгол Улс, гадаад улсын төрийн байгууллагын хооронд харилцан тохиролцсон албан томилолт болон ажиллаж байгаа төрийн байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргээ гүйцэтгэхдээ аж ахуйн нэгж, иргэн, түүний дотор гадаадын байгууллага, иргэний зардлаар гадаад, дотоодод зорчих;

~~14.1.6./Энэ заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

15.1.7.албаны бус зорилгод төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглан завших;

15.1.8.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдох, аж ахуйн нэгж, нам, олон нийтийн бусад байгууллагад орон тооны албан тушаал хавсран гүйцэтгэх;

/Энэ заалтад 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

Тайлбар: Энэ хуулийн 15.1.8-д аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдохыг хориглосон нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10.5-д заасны дагуу төрийн захиргааны албан тушаал эрхлэх аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид хамаарахгүй.

/Энэ тайлбарыг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар нэмсэн/

15.1.9./Энэ заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.1.10./Энэ заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.1.11./Энэ заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.1.12./Энэ заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.1.13./Энэ заалтыг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

15.1.14.Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох, түүнд зориулалтын бус төсвийн хөрөнгө зарцуулах, төрийн өмч хөрөнгийг дайчлах, албаны унаа ашиглах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

15.1.15.иргэнийг Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн 4.1.5, 4.1.6, 6.4-т заасан жендэрийн шууд ба шууд бус хэлбэрээр ялгаварлан гадуурхах;

/Энэ заалтыг 2011 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн/

15.1.16.нийтийн сонсголыг зохион байгуулан явуулах, сонсголд оролцох журмыг зөрчих.

/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛ ЭРХЛЭХ БОЛЗОЛ, ЖУРАМ**

16 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзол

16.1.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол болон нам, олон нийтийн бусад байгууллагын харьяалал зэргээр ялгаварлаж үл болно.

/Энэ хэсэгт 2011 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

16.2.Төрийн жинхэнэ албан тушаалд дараахь тохиолдолд авч ажиллуулахыг хориглоно:

~~16.2.1.хуульд өөрөөр заагаагүй бол Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, эсхүл бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээд ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дуусаагүй;~~

/Энэ заалтыг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон бөгөөд 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн/

16.2.2.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалаас сахилгын шийтгэлээр халагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй;

/Энэ заалтад 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

16.2.3.хууль тогтоомжоор зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу шууд хяналт тавих албан тушаалтантай гэр бүл, төрөл, садангийн хүн нь тухайн ажлын албаны нэгжид хамт ажиллахаар бол;

16.2.4.хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн төрийн албаны онцлог төрөл болох энэ үүргээ биелүүлээгүй бол;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

Тайлбар: 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө 18 нас хүрсэн, түүнчлэн эмнэлгийн магадлагаагаар эрүүл мэндээр тэнцээгүй, хуульд заасан бусад үндэслэлээр цэргийн жинхэнэ албанаас түр буюу бүрмөсөн чөлөөлөгдсөн иргэнд энэ заалт хамаарахгүй.

/Энэ тайлбарыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

16.2.5.гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

/Энэ заалтын дугаарт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

16.2.6.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.

/Энэ заалтын дугаарт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

16.3.Энэ зүйлийн 16.2, мөн хуулийн 17.1, 17.4-т заасныг зөрчиж иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг төрийн албаны төв байгууллага хүчингүйд тооцож, буруутай албан тушаалтанд шүүгч холбогдох хуульд заасан хариуцлага оногдуулна.

/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт, 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

17 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах

17.1.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө.

17.2.Энэ хуулийн 10.1-д заасан ерөнхий болон 33.5-д заасан тусгай шаардлага, 16 дугаар зүйлд заасан болзлыг хангасан Монгол Улсын иргэн төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхтэй.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

17.3.Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх хүсэлтэй, энэ хуулийн 10.1-д заасан ерөнхий болон 33.5-д заасан тусгай шаардлагыг хангасан иргэдийг өрсөлдүүлэн шалгаруулах зорилгоор тэднээс төрийн албаны мэргэшлийн шалгалт /цаашид “мэргэшлийн шалгалт” гэх/ авч онооны дэс дарааллаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэнэ. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний сонгон шалгаруулалтад тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа нэг иргэнийг төрийн албаны төв байгууллага сонгон түүнийг томилох эрх бүхий этгээдэд нэр дэвшүүлнэ.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

17.4.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 17.1-д заасан албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих онцлог шаардлагыг харгалзан шалгаруулж авах тухай хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад тавина.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

17.5.Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй.

17.6.Мэргэшлийн шалгаруулалтаар шалгарсан иргэнийг зохих албан тушаалд томилсон тухай төрийн холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаж баталгаажуулна.

17.7.Энэ хуулийн 23.2, 24.1.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдсөн, 25 дугаар зүйл, 26.1.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас халагдсан хүмүүс төрийн жинхэнэ албанд эргэж ороход энэ зүйлд заасан журмын дагуу мэргэшлийн шалгалт өгнө.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

17.8.Төрийн захиргааны болон энэ хуулийн 17.9-д зааснаас бусад тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах болзол, журам, түүнчлэн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журмыг төрийн албаны төв байгууллага тогтооно.

/Энэ хэсэгт 2003 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

17.9.Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцэн гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн шүүгчийн албан тушаал эрхлэх, прокуророор ажиллахад энэ хуулийн 17.3-т заасан мэргэшлийн шалгалтаас чөлөөлөгдөнө.

/Энэ хэсгийг 2003 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн, 2007 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

17.10.Энэ хуулийн 17.9-д заасан албан тушаалд ажиллаж байгаа этгээд төрийн жинхэнэ албаны өөр албан тушаалд шилжиж ажиллахад төрийн албаны мэргэшлийн шалгалт өгнө.

/Энэ хэсгийг 2003 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн/

17.11.Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах улс төрийн албан тушаал эрхэлж байсан төрийн албан хаагчийг Төрийн албаны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж болно.

/Энэ хэсгийг 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2003 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

~~17.12./Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

~~17.13./Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/~~

17.14.Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага нь төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд орох иргэний бэлтгэл нөөцийн санг төрийн албаны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу бүрдүүлнэ.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

17.15.Төрийн албаны төв байгууллага нь төрийн албаны бэлтгэл нөөцийн нэгдсэн санг эрхэлж, төрийн жинхэнэ албаны сул орон тоог төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын захиалгын үндсэн дээр нөхөх үйл ажиллагааг зохицуулан зохион байгуулна.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

17.16.Энэ хуулийн 17.4-т заасан сонгон шалгаруулалт болон 17.3-т заасан мэргэшлийн шалгалтад орж адил оноо авсан боловч хүйсийн шинжээр тэнцээгүй иргэн төрийн албаны төв байгууллагад гомдлоо гаргаж болно.

/Энэ хэсгийг 2011 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар нэмсэн/

18 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албаны туршилтын хугацаа

18.1.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орсон албан хаагчид туршилтын хугацааг 1 жил хүртэл хугацаагаар тогтоож болно.

18.2.Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журмыг төрийн албаны төв байгууллага тогтооно.

19 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх

19.1.Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд зохих журмын дагуу үнэлж дүгнэнэ.

19.2.Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн албан тушаал дэвшүүлэх, зохих шатны сургалтад хамруулах, цол, зэрэг дэв олгох, цалин хөлсийг өөрчлөх, шагнаж урамшуулах, албан тушаал бууруулах асуудлыг шийдвэрлэнэ.

19.3.Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмыг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага тогтооно

20 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв

/Энэ зүйлийн гарчигт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

20.1.Төрийн жинхэнэ тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаал нь тус бүртээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

20.2.Тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч; эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхий сайд; ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын сайд, төрийн бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан, аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус олгоно.

20.3.Зэрэг дэв олгохдоо төрийн албанд ажилласан буюу тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзана.

20.4.Төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/

20.5.Төрийн албаны зарим онцлог салбарын албан тушаалын зэрэг дэвийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн хуулиар тогтоож болно.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

21 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх

21.1.Төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж болно.

21.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмыг Засгийн газар тогтооно.

22 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

22.1.Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно.

22.2.Төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

22.3.Энэ зүйлийн 22.2-т заасан төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь эгүүлэн авна.

22.4.Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах журмыг Төрийн албаны төв байгууллага тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

22.5.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалах арга хэмжээнд хамрагдсан албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно.

/Энэ хэсгийг 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/

23 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаалаас нь бууруулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх

23.1.Төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилгаар албан тушаал бууруулж болно:

23.1.1.албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн;

23.1.2.үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь төрийн тухайн албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй болсон.

23.2.Төрийн жинхэнэ албан хаагч Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших бол тухайн ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших бол тухайн ээлжит сонгуулийн жилийн дөрөвдүгээр сарын нэгний өдрөөс өмнө, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших бол санал авах өдрөөс гурван сарын өмнө тус тус төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших бол ээлжит сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас чөлөөлөгдсөн байна. Сонгуульд нэр дэвшихтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагч өргөдлөө гаргаагүй нь тухайн төрийн байгууллага түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй.

/Энэ хэсэгт 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт, 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

23.3.Төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилгаар төрийн албанаас түр чөлөөлнө:

23.3.1.хуульд өөрөөр заагаагүй бол биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 1 жилээс дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон;

23.3.2.гурван сараас дээш хугацааны сургалтаар (шинэ дадлага, туршлага эзэмших сургалтыг оролцуулан) бэлтгэгдэх болсон;

/Энэ заалтад 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

23.3.3.цэргийн жинхэнэ алба хаах болсон;

23.3.4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан.

/Энэ заалтыг 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/

23.4.Төрийн жинхэнэ албан хаагч төрийн улс төрийн албан тушаалд сонгогдон буюу томилогдон ажиллах болсон, эсхүл төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдон ажиллах болсон, тухайн төрийн байгууллага нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буугдсан, бүтцийн өөрчлөлт орж орон тоо хасагдсан бол түүнийг төрийн жинхэнэ албанаас чөлөөлнө.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

23.5.Энэ зүйлийн 23.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, мөн зүйлийн 23.4-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийг нөөцөд байгаад тооцно.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

24 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдөх

24.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр төрийн албанаас чөлөөлнө:

24.1.1.тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

24.1.2.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;

24.1.3.өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан.

24.2.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаарт хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэр гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц болон төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтоосон хугацаа дуусмагц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргаагүй нь захиргааны санаачлагаар түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй.

/Энэ хэсгийг 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

24.3.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн алба хаах насны дээд хязгаар нь 65 нас байна.

24.4.Төрийн захиргааны албан хаагч нь төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

24.5./Энэ хэсгийг 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон/

25 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албанаас халах

25.1.Төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр төрийн албанаас хална:

25.1.1.Хуульд өөрөөр заагаагүй бол удаа дараа /2 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн;

/Энэ заалтыг 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

25.1.2.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

25.1.3.Монгол Улсын харьяатаас гарсан.

26 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах

26.1.Энэ хуулийн 13, 15, 40 дүгээр зүйлд заасныг зөрчсөн болон албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг харгалзан хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчид дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна:

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт, 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

26.1.1.сануулах;

26.1.2.албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

26.1.3.төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

26.2.Энэ зүйлийн 26.1-д заасан сахилгын шийтгэлийг заавал дэс дараалан хэрэглэх шаардлагагүй.

26.3.Төрийн жинхэнэ албан хаагчид түүнийг томилсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулна.

26.4.Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

26.5.Нэг төрлийн сахилгын шийтгэлийг давхардуулан ногдуулж болохгүй.

26.6.Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

26.7.Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

26.8.Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор төрийн дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд гаргаж болно.

26.9.Сахилгын шийтгэл ногдуулах, түүнд төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журмыг Засгийн газар тогтооно.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, БАТАЛГАА

27 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн баталгаа

27.1.Төрийн албан хаагч дараахь баталгаагаар хангагдана:

27.1.1.төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж авах;

27.1.2.албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах;

27.1.3.гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн авах;

27.1.4.албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүн нь тухайн төрийн албан хаагчийн ажиллаж байгаа төрийн байгууллагаар хамгаалуулах;

27.1.5.төрөөс орон байраар хангагдах;

27.1.6.Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдлэх;

27.1.7.төрийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах;

27.1.8.Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэл

бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах;

27.1.9.төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах;

27.1.10./Энэ заалтыг 2011 оны 7 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

27.1.11.хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаа.

27.2.Төрийн жинхэнэ албан хаагч дараахь нэмэгдэл баталгаагаар хангагдана:

27.2.1.энэ хуулийн 25 дугаар зүйл, 26.1.3-т зааснаас бусад тохиолдолд төрийн албанаас халагдахгүй байх;

27.2.2.Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг даргын бүрэн эрх дуусгавар болох, мөн энэ хуульд заасан улс төрийн албан тушаалтан уг албан тушаалаас өөрчлөгдөх нь төрийн жинхэнэ албан хаагчийг өөрчлөх үндэслэл болохгүй байх;

27.2.3.төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), эсхүл зохион байгуулалтын бүтэц нь өөрчлөгдсөн боловч төрийн албан хаагчийн албан тушаал (ажлын байр)-ын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол түүнийг уг албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)-ын орон тоо цөөрсөн бол уг албан тушаалыг эрхэлж байсан албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, мэдлэг, ур чадвар, ажлын дадлага, туршлага зэргийг нь харгалзан тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа албан хаагчийг томилох эрх бүхий албан тушаалтан нь шалгаруулж авна;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

27.2.4.төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд шилжих буюу төрийн хөрөнгөөр 6 сар хүртэл хугацаагаар дахин мэргэшиж болох бөгөөд энэ хугацаанд урьд нь эрхэлж байсан албан тушаалынхаа цалин хөлсийг авч, хууль тогтоомжид заасан журмын дагуу ажлын байраар хангуулах, эсхүл 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг тухайн байгууллагаас олгоно;

/Энэ заалтад 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт, энэ заалтын дугаарт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт, энэ заалтад 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

27.2.5.төрийн байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах албан хаагчид аминдаа орон сууц барих болон орон сууц, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйлс худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь

зориулан байгууллагаас нь хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгөх.

/Энэ заалтын дугаарт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

27.3.Энэ хуулийн 6.1.6-6.1.11-д заасан улс төрийн албан тушаалтан ээлжит сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол түүнд урьд авч байсан албан тушаалын 6 сарын хугацааны цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно.

27.4.Энэ хуулийн 27.1.5, 27.1.8, 27.2.5-д заасан нэмэлт баталгаатай холбогдох журмыг Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

28 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн цалин хөлс

28.1.Төрийн албан хаагчид албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.

28.2.Төрийн албан хаагчийн цалин хөлс нь:

28.2.1.улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс;

28.2.2.төрийн захиргааны албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс;

/Энэ заалтад 2007 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

28.2.3.тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс;

28.2.4.үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон докторын, мэргэшлийн зэрэг, цол, ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдлээс тус тус бүрдэнэ.

28.3.Төрийн жинхэнэ албан хаагчид цол, зэрэг дэвийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

28.4.Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишгийг тогтооход дараахь шаардлагыг харгалзан үзнэ:

28.4.1.төрийн адил албан тушаалд адил хэмжээний цалин хөлс тогтоох;

28.4.2.төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь нийгмийн амьжиргааны дундаж түвшин болон хувийн хэвшилд ажиллагчдын албан тушаалын цалингийн дундаж түвшинтэй уялдсан байх;

28.4.3.төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишгийг албан тушаалын ангилал, зэрэглэл болон төрийн тухайн албан тушаал эрхэлсэн хугацаанаас хамааралтайгаар төрийн албаны салбар, төрийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр боловсруулж мөрдүүлэх;

28.4.4.төрийн албаны төв байгууллага нь Үндэсний статистикийн хороо, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох эрх бүхий төрийн бусад байгууллагын оролцоотойгоор хувийн хэвшилд ажиллагчдын адилтгах албан тушаалын дундаж цалингийн судалгааг Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу жил бүр гаргах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

28.4.5.төрийн албан хаагчийн албан тушаалын дундаж цалингийн хэмжээ нь хувийн хэвшилд ажиллагчдын адилтгах албан тушаалын цалингийн дунджаас 5.0 буюу түүнээс дээш хувиар бага болсон тохиолдолд албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээ, жишгийг нэмэгдүүлэх тухай саналыг Төрийн албаны төв байгууллага хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэхийн өмнө Улсын Их Хуралд танилцуулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

28.5.Улс төрийн болон тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч /сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч, зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тусгай албан тушаалаас бусад/-ийн албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар “хилийн” гэсний дараа “ба дотоодын” гэж нэмэлт оруулсан бөгөөд 2017 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн/

28.6.Дор дурдсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишгийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно:

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

28.6.1.сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;

28.6.2.төрийн захиргааны албан хаагч;

28.6.3.зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан;

/Энэ заалтад 2003 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн хууль, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хууль, 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөлт, 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

28.6.4.үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагч.

28.7.Улс төрийн болон энэ хуулийн 8.1.1-8.1.3-т заасан тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдлийн хэмжээ, зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн хууль тогтоомжоор тогтооно.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

28.8.Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл олгох журам, хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

28.9.Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

28.10.Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

/Энэ хэсгийг 2002 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хууль, 2011 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан/

28.11.Энэ хуулийн 28.10-т заасан албан тушаалын цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Улсын Ерөнхий прокурор, Улсын Ерөнхий прокурорын орлогч хамаарахгүй.

/Энэ хэсгийг 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2018 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

28.12.Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлж цагаар тооцож болно. Цалин хөлсийг цагаар тооцох ажлын байрны жагсаалтыг Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсгийн дугаарт 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

28.13.Энэ зүйлийн 28.2 дахь хэсэгт заасан цалингийн нэмэгдлийн дээд хэмжээ нь төрийн албан хаагчийн цалин хөлсний 40 хувиас хэтрэхгүй байна.

/Энэ хэсгийг 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсгийн дугаарт 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

28¹ дүгээр зүйл.Албан тушаалтны цалин хөлсний талаар санал гаргах

28¹.1.Төрийн албаны төв байгууллага нь энэ хуулийн 35¹.1-д заасан албан тушаалтны цалин хөлсний талаар дараах этгээдэд санал гаргана:

28¹.1.1.Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, дэд даргын талаар төсвийн ерөнхийлөн захирагчид;

28¹.1.2.төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн даргын талаар төсвийн ерөнхийлөн захирагчид;

28¹.1.3.Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын төсвийн шууд захирагчийн талаар Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвлөлдөж Улсын Их Хуралд;

28¹.1.4.Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын даргын талаар төсвийн ерөнхийлөн захирагчид;

28¹.1.5.аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын талаар тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад.

28¹.2.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгчийн цалин хөлс, урамшуулалтай холбогдсон асуудлыг тус тусын хуулиар зохицуулна.

28¹.3.Төрийн албаны төв байгууллага нь удирдах албан тушаалтны цалин хөлсний талаар санал боловсруулахдаа албан тушаалаас нь гадна ажлын үр дүнгээс хамаарах чиглэлийг баримтлан дараах зүйлийг харгалзан үзнэ:

28¹.3.1.адил албан тушаалд ижил хэмжээний цалин хөлс тогтоох;

28¹.3.2.тухайн албан тушаалын хариуцлагын түвшинг харгалзах;

28¹.3.3.тухайн албан тушаалаар хүлээсэн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадварыг харгалзах.

28¹.4.Төсвийн ерөнхийлөн захирагч энэ хуулийн 28¹.1-д заасан цалин хөлсний хэмжээг тогтоохдоо төрийн албаны төв байгууллагын саналыг харгалзаж үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг үндэслэнэ.

/Энэ зүйлийг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/

29 дүгээр зүйл.Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр

29.1./Энэ хэсгийг 2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

29.2.Төрийн албан хаагчид дараахь нөхөх төлбөр олгоно:

29.2.1.албан томилолтын зардал;

29.2.2.албан ажлын хэрэгцээнд батлагдсан нормативын дагуу хувийн унаа албан ажилдаа хэрэглэсэн тохиолдолд хувиас гарсан зардал;

29.2.3.гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор төрийн байгууллагад ажиллахаар томилогдсон албан хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжинд нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардал;

29.2.4.хууль тогтоомжид заасан бусад нөхөх төлбөр.

29.3.Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, түүний хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

30 дугаар зүйл.Төрийн албан хаагчид олгох тусламж

30.1.Энэ хуулийн 23.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, мөн хуулийн 23.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид тусламж олгож болно.

30.2.Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчид үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт, 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт, 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

30.3.Хуульд өөрөөр заагаагүй бол албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд түүний ар гэрт 3 жилийн албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

30.4.Төрийн албан хаагчид нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжээс гадна дараахь тохиолдолд тусламж олгож болно:

30.4.1.гэр бүлийг нь дэмжих;

30.4.2.ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгох;

30.4.3.гэр бүл, төрөл, садангийн хүн нас барах, өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон гэр бүлийн гишүүнээ тэтгэх;

30.4.4.хууль тогтоомжид заасан бусад тусламж.

30.5.Төрийн албан хаагчид тусламж олгох нөхцөл, журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн шагнал, урамшил

31.1.Төрийн албан хаагчид албан тушаалын бүрэн эрхээ үр дүнтэй биелүүлж өндөр амжилт гаргасан гавьяа зүтгэлийг нь үнэлж төрийн байгууллагын захиргаа түүнийг дараахь байдлаар шагнаж, урамшуулна:

31.1.1.мөнгөн шагнал олгох;

31.1.2.эд зүйл болон үнэ бүхий зүйл дурсгах;

31.1.3.Засгийн газар ба төрийн дээд байгууллагаас шагнуулахаар тодорхойлох.

31.2.Төрийн албан хаагчид энэ зүйлийн 31.1.1-д зааснаас гадна улирлын ажлын үр дүнгээр болон онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсний төлөө мөнгөн урамшил олгоно.

31.3.Төрийн албан хаагчийг энэ зүйлийн 31.1.1, 31.1.2-т заасан шагналаар шагнах болон мөн зүйлийн 31.2-т заасан мөнгөн урамшил олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар, энэ зүйлийн 31.1.3-т зааснаар шагналд тодорхойлох журмыг хуулиар тус тус тогтооно.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

31.4.Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшил олгож болно.

32 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмж

32.1.Төрийн албан хаагчид тэтгэвэр, тэтгэмж олгох, тэтгэврийн сан байгуулах, зарцуулах журмыг хуулиар зохицуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН АЛБАНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

33 дугаар зүйл.Төрийн албаны удирдлага

33.1.Төрийн албан хаагчийн ерөнхий удирдлагыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

33.2.Төрийн албан хаагчийн стандартын удирдлагыг төрийн албаны төв байгууллага хэрэгжүүлнэ.

33.3.Төрийн албан хаагчийн шуурхай удирдлагыг төрийн байгууллагын ажлын албаны эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ.

33.4.Энэ хуулийн 35¹.1-д заасан төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн, энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

33.5.Энэ хуулийн 33.4-т зааснаас бусад төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг төрийн жинхэнэ албан тушаалын ангилал, зэрэглэл бүрээр төрийн албаны төв байгууллага тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

33.6.Төрийн байгууллага нь дараахь хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ:

33.6.1.төрийн албан хаагчийн сургалт;

33.6.2.төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа

/Энэ хэсгийг 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсгийн дугаарт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

34 дүгээр зүйл.Төрийн албаны төв байгууллага

34.1.Төрийн албаны төв байгууллага нь Төрийн албаны зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ мөн.

34.2.Зөвлөл нь хараат бус бие даасан байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

34.3.Зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд дарга, 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Тэдгээрийн 2 нь орон тооны, 4 нь орон тооны бус байна.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

34.4.Зөвлөлийн орон тооны 2 гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр нэг хүний нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, мэргэшсэн, ял шийтгэлгүй, 40 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

34.5.Улсын Их Хурал Зөвлөлийн орон тооны гишүүнийг 6 жилийн хугацаагаар томилно.

34.6.Зөвлөлийн орон тооны гишүүнээр нэг удаа улируулан томилж болно.

34.7.Зөвлөлийн даргыг Ерөнхийлөгчийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилж бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, удирдах ажлын дадлага, туршлагатай, ял шийтгэлгүй, 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

34.8.Зөвлөлийн орон тооны бус гишүүн нь дор дурдсан албан тушаалтан байна:

34.8.1.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;

34.8.2.Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга;

34.8.3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;

34.8.4.Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга.

34.9.Зөвлөлийн орон тооны 3 гишүүний дотор нэг нутгийн болон нэг анги хамт төгссөн хоёр хүн байж болохгүй.

/Энэ хэсэгт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

34.10.Зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг Улсын Их Хурал батална.

34.11.Зөвлөлийн орон тооны гишүүн нь гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль ноцтой зөрчсөн бол түүнийг уг албан тушаалаас нь эгүүлэн татах тухай асуудлыг Зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

34.12.Зөвлөлийн орон тооны гишүүнээр нөхөн томилогдсон хүн нь орон гарсан өмнөх хүнийхээ бүрэн эрхийн үлдсэн хугацаанд уг албыг хашина.

34.13.Зөвлөл нь орон тооны болон орон тооны бус салбар зөвлөл, ажлын албатай байна. Ажлын албаны даргыг Төрийн албаны зөвлөл томилж, чөлөөлнө. Орон тооны салбар зөвлөл болон ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийг Улсын Их Хурал батална.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

34.14.Зөвлөлийн орон тооны гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол цалин хөлсөө бууруулахгүйгээр мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил эрхлэх хүртэлх 3 сарын хугацаанд урьд авч байсан цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэлэг олгоно.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

35 дугаар зүйл.Зөвлөлийн бүрэн эрх

35.1.Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.1.төрийн албаны шинэтгэлийн стратегийн төлөвлөлт, төрийн боловсон хүчний бодлогын удирдамжаар хангах, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.2.төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартын хэрэгжилтийг шалган зааварлах, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих, энэ хуулийн 39.1-д заасан маргааныг хянан шийдвэрлэх, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.3.хууль тогтоомжийн актад нийцүүлэн эрх хэмжээнийхээ асуудлаар шийдвэр гаргах, өөрчлөх, биелэлтийг нь хангах;

35.1.4.төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, төрийн алба, төрийн албан хаагчтай холбогдолтой шаардлагатай мэдээллээр Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, бусад сонирхогч этгээдийг хангах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

/Энэ заалтад 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

35.1.5.төрийн байгууллагын ажлын албаны төрийн жинхэнэ албан хаагчийн удирдлагатай холбогдсон үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, төрийн байгууллагын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох болон төрийн үйлчилээний чанар, хүртээмжид нийгмийн аудит хийх арга зүйг нэвтрүүлэх талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх замаар төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх болон төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.6.төрийн захиргааны болон хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай албаны удирдах албан тушаалд томилогдох нэг ажилтныг Улсын Их Хурлаас тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулж, нэр дэвшигчийн талаархи дүгнэлтээ уг ажилтныг томилох эрх бүхий байгууллагад өгөх;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.7.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтанд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.8.төрийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн төлөвлөлтийн арга зүйн удирдлагаар хангах, төрийн жинхэнэ албаны боловсон хүчний хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.9.төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын ажлыг арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.10.төрийн жинхэнэ албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, удирдах ажилтны манлайлах ур чадварыг нэмэгдүүлэх сургалт болон төрийн албатай холбогдсон судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, зохицуулах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.11.төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг боловсруулан батлахад санал өгөх, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийхэд мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.12.төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ (мониторинг), үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах, улсын болон орон нутгийн төсвийн удирдлагын зардлын төслийг зохиох, хянаж батлахад зохих журмын дагуу санал гаргах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.13.төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

35.1.14.төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх, өөрчлөлтийн менежмент, төрийн захиргааны болон хүний нөөцийн менежментийн асуудлаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтныг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр хангах;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

35.1.15.төрийн албаны чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагаас төрийн албанд олгож буй зээл, тусламжийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаархи мэдээллийг судлан боловсруулж, тэдгээрийн давхардал, хийдэгдлийг арилгах, үр нөлөөг дээшлүүлэх талаар зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

35.1.16.хуульд заасан бусад бүрэн эрх.

/Энэ заалтын дугаарт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

35¹ дүгээр зүйл.Төрийн байгууллагын зарим удирдах албан тушаалд нэр дэвшүүлэх журам

35¹.1.Төрийн албаны төв байгууллага дараах албан тушаалд нэг хүний нэрийг дэвшүүлж, түүнийг томилох эрх бүхий этгээдэд санал болгоно:

35¹1.1.Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга;

35¹1.2.Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга;

35¹.1.3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;

35¹.1.4.төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;

35¹.1.5.Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын төсвийн шууд захирагч;

35¹.1.6.агентлагийн дарга цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон зэвсэгт хүчний байгууллагаас бусад;

35¹.1.7.Улсын ерөнхий прокурорын газрын Тамгын газрын дарга;

35¹.1.8.аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга.

35¹.2.Төрийн албаны төв байгууллага нь сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэхээс ажлын 21-ээс доошгүй өдрийн өмнө тухайн албан тушаалын талаар нийтэд мэдээлнэ.

35¹.3.Энэ хуулийн 35¹.1-д заасан албан тушаалтныг сонгон шалгаруулж нэр дэвшүүлэхэд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, бусад төсвийн ерөнхийлөн захирагч, улс төрийн аливаа нам, эвслийн зүгээс төрийн албаны төв байгууллагад нөлөө үзүүлэхийг хориглоно.

35¹.4.Төрийн албаны төв байгууллага нь албан тушаалд нэр дэвшигчийг төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулан, хэрхэн сонгосон тухайгаа нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтын хамт нийтэд мэдээлнэ.

35¹.5.Томилох эрх бүхий этгээд төрийн албаны төв байгууллагаас энэ хуулийн 35¹.1-д заасан албан тушаалд санал болгосон нэр дэвшигчийг холбогдох албан тушаалд томилно.

35¹.6.Томилох эрх бүхий этгээд төрийн албаны төв байгууллагын санал болгосон нэр дэвшигчийг томилохоос хуульд заасан үндэслэлээр 1 удаа татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд төрийн албаны төв байгууллага өөр хүнийг зохих журмын дагуу санал болгоно.

35¹.7.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгчийг томилох, чөлөөлөхтэй холбогдсон асуудлыг тус тусын хуулиар зохицуулна.

/Энэ зүйлийг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/

36 дугаар зүйл.Төрийн албаны стандарт

36.1.Төрийн албаны стандарт нь төрийн албыг үр дүнтэй удирдах, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэнэ.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

36.2.Төрийн албаны стандарт нь төрийн байгууллага чиг үүргээ, төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн менежментийн үйл ажиллагаанд тавих шаардлагыг тогтооно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

36.3.Төрийн албаны стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу боловсруулан баталж мөрдүүлнэ.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, энэ хэсэгт 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

37 дугаар зүйл.Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэл

37.1.Төрийн албан хаагчийн хувийн хэрэг /цаашид “хувийн хэрэг” гэх/ нь төрийн албан хаагчийн тухай болон түүний төрийн албан тушаал эрхэлсэн тухай мэдээлэл агуулна.

37.2.Төрийн албан хаагчид зөвхөн нэг хувийн хэрэг хөтөлнө.

37.3.Төрийн албаны төв байгууллага нь төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд уг бүртгэлд төрийн албан тушаал эрхэлж байгаа болон нөөцөд байгаа төрийн бүх албан хаагчийн тухай мэдээ агуулсан байна.

37.4.Хувийн хэрэг, тоо бүртгэл хөтлөх журмыг төрийн албаны төв байгууллага тогтооно.

38 дугаар зүйл.Төрийн албаны санхүүжилт

38.1.Төрийн албаны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

38.2.Төрийн албаны зардлыг бууруулах арга хэмжээ авч төсвийн санхүүжилтийг хорогдуулах нь төрөөс олгож байгаа төрийн албан хаагчдад олгох төлбөрийг түр буюу бүрмөсөн зогсоох, тэдний цалин хөлсийг бууруулах үндэслэл болохгүй.

/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

38.3.Төрийн албаны санхүүжилт болон төрийн байгууллагын төсөвт хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

38.4./Энэ хэсгийг 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

39 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдсэн тухай маргааныг хянан шийдвэрлэх

39.1.Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан дараахь маргааныг

хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн албаны төв байгууллага хянан шийдвэрлэнэ:

39.1.1.энэ хуулийн 17.2, 19.2, 23, 25, 26 дугаар зүйлд заасан асуудлаар төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн өөрийнх нь гаргасан маргаан;

39.1.2.Энэ хуулийн 35.1.6-д заасны дагуу томилогдсон буюу чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтан, уг албан тушаалд нэр дэвшигчийн өөрийнх нь гомдлоор үүссэн маргаан;

/Энэ заалтыг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

39.1.3.төрийн жинхэнэ албан хаагчаас цалин хөлс, ажиллах нөхцөл, баталгааны талаар гаргасан бусад маргаан.

/Энэ заалтад 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ заалтын дугаарт 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

~~39.2.~~*/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

39.3.Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журмыг Улсын Их Хурал тогтооно.

39.4.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч энэ хуулийн 39.1-д заасан маргаантай холбогдсон гомдлоо төрийн албаны салбар зөвлөл болон төрийн албаны төв байгууллагад 1 сарын дотор гаргана.

/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

39.5.Төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн удирдлагатай холбогдон гарсан эрх бүхий албан тушаалтны шийдвэр хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдсон бол төрийн албаны төв байгууллага өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

39.6.Төрийн албаны төв байгууллагын гаргасан шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

39.7.Төрийн албаны төв байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрсөн тал уг шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

/Энэ хэсгийг 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн/

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

40 дүгээр зүйл.Хориглох зүйл

40.1.Төрийн албан хаагч, иргэнээс мэргэшлийн шалгалт авах, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, түүнийг томилох, чөлөөлөх, албан тушаалд дэвшүүлэх, албан тушаалаас бууруулах зэрэг асуудлаар хууль тогтоомж, стандартыг зөрчих, түүнчлэн дээрх үйл ажиллагаатай холбогдсон шударга бус тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно.

40.2./Энэ хэсгийг 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

41 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

41.1.Төрийн албан хаагч энэ хууль болон бусад хуулийг зөрчсөн тохиолдолд энэ хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ОЧИР**

С.ТӨМӨР-
